

## **ТАНИЛЦУУЛГА**

**/Дэлгэрэнгүй/**

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны бодлого, Засгийн газрын “2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 35 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх зорилгоор дараах хууль тогтоомжийн төслийг боловсруулаад байна.

### **1.Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Улсын Их Хурлаас 2022 оны 7 дугаар сарын 21-ний өдөр Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулга буюу Хууль зүйн туслалцааны тухай хуулийг Улсын Их Хурлаас баталж 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

Хууль зүйн туслалцааны тухай хуульд зааснаар улсын өмгөөллийн үйлчилгээг зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагчаар хязгаарлахгүйгээр, доор дурдсан хүнд өмгөөллийн үйлчилгээ үнэ төлбөргүй үзүүлж байна:

- Эрүүгийн хуулийн Арван хоёрдугаар бүлэг /Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг/, Арван дөрөвдүгээр бүлгийн 14.1 дүгээр зүйл /Ялгаварлан гадуурхах/, Арван зургадугаар бүлэг /Хүүхдийн эсрэг гэмт хэрэг/-т заасан гэмт хэргийн 18 насанд хүрээгүй хохирогч, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч хүсэлт гаргасан;
- Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл /Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх/, 13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/-д заасан гэмт хэргийн хохирогч төлбөрийн чадваргүй, эсхүл хохирогч нь 18 насанд хүрээгүй бол түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч хүсэлт гаргасан;
- төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан;
- хүүхдийн тэтгэлэг гаргуулах нэхэмжлэгч төлбөрийн чадваргүй бол;
- үл хөдлөх эд хөрөнгө, газар өмчлөх эрх нь зөрчигдсөн захиргааны хэргийн оролцогч төлбөрийн чадваргүй бол;
- Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.1-д заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд.

Харин Гэмт хэргийн гэрч хүүхэд, Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйл /Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих/, 6.20 дугаар зүйл /Хүүхдийн эрхийг зөрчих/-д заасан зөрчлийн улмаас эрх нь зөрчигдсөн хүүхэд. түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлт, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгчийн хүсэлтээр өмгөөллийн үйлчилгээ үнэ төлбөргүй үзүүлж болохоор заасан.

Мөн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу хамгаалалтад байгаа гэрч, хохирогч болон хүүхдийн тэтгэлэг гаргуулах маргаанд нэхэмжлэгчээр, үл хөдлөх эд хөрөнгө, газар өмчлөх эрх нь зөрчигдсөн захиргааны маргаанд ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх хууль зүйн туслалцаа авч болох зохицуулалт тус тус үйлчилж байна.

Хууль зүйн туслалцааны тухай хууль нь Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, хөндөгдсөн хүний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, төрөөс хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх хүрээ, тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтоох зорилготой боловч мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт зааснаар "...хууль зүйн туслалцааг хуульд харшлахгүй арга, хэлбэрээр явуулах бөгөөд хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэж хууль зүйн туслалцаа үзүүлэх үндсэн процедурын асуудлыг хуульчлалгүй журмаар, төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүн, ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг сайд нарын баталсан журмаар зохицуулж байна.

2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаас хуулиар тусгайлан эрх олгосон заалтад дүн шинжилгээ хийж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахыг сайд нарт даалгасан. Иймд хүний эрх, эрх чөлөөг хөндсөн, харилцаанд оролцогчийн эрх, үүргийг тогтоосон буюу процессын шинжтэй зохицуулалт агуулсан, журмаар зохицуулсан харилцааг тухайн хуульд тусган боловсруулах шаардлага бий болсон.

Ийнхүү хууль зүйн туслалцаа үзүүлэх журам, мөн нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст үнэ төлбөргүй үзүүлэх хууль зүйн туслалцааны төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх хуульд заасан хэрэг, маргаанд хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбоотой журмаар зохицуулж байсан харилцааг хуулийн төсөлд тусгаж, холбогдох эрх олгосон заалтыг хүчингүй болгохоор хуулийн төсөл боловсрууллаа.

Түүнчлэн, олон улсын хүний эрхийн гэрээ конвенцоор гэрч, хохирогчийг хамгаалах, ялангуяа гэрч, хохирогч хүүхдийг хамгаалах, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг төрөөс баталгаажуулахыг байнга зөвлөсөөр ирсэн. Иймд хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлж болох агуулгаар тусгасныг заавал үзүүлэхээр өөрчилж, мөн хүн худалдаалах гэмт хэргийн насанд хүрсэн хохирогч нь төлбөрийн чадваргүй тохиолдолд л туслалцаа үзүүлэхээр заасныг энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг заавал төлбөрийн чадваргүй байхыг шаардахгүй байхаар өөрчлөн хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн хүрээ хязгаарыг өргөжүүлж хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч боловсрууллаа.

Түүнчлэн, Хууль зүйн туслалцааны тухай хуульд заасан үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх шаардлагатай нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд мэргэжлийн өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхэд Хууль зүйн туслалцааны төв болон Монголын Өмгөөлөгчдийн холбооны хамтран баталсан 2024 оны А/3, А/15 дугаар журмаар зохицуулж байна. Өмгөөллийн тухай хуульд заасан нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэх зохицуулалт, Хууль зүйн туслалцааны тухай хуульд заасан үнэ төлбөргүй үзүүлэх хууль зүйн туслалцаанд хувийн өмгөөлөгч оролцуулах зохицуулалтыг уялдуулан практикт тогтсон зарим харилцааг хуульд тусгах замаар өөрчлөн боловсрууллаа.

Энэ нь төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн хүнд үзүүлэх хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулж Монгол Улсын үндсэн хуульд заасан иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахад чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

## **2.Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ ... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, “...эрхийг хүн бүр баталгаатай эдлэх”, 55 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрх”, 2 дахь хэсэгт заасан “шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа авна” хэмээн Монгол Улсын иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаажуулсан байдаг.

Хуульчийн хувьд бусдаас хөлс авахгүйгээр нийтийн тусын тулд болон нийгмийн эмзэг хэсгийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах зорилгоор үзүүлж байгаа хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ, эрх зүйн иргэний боловсролыг дэмжих зорилготой үйл ажиллагааг буюу нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Өмгөөллийн тухай, Хууль зүйн туслалцааны тухай хуулиар ерөнхий байдлаар зохицуулж байна.

Хууль зүйн туслалцааны тухай хуульд заасан үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх шаардлагатай нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд мэргэжлийн өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхэд Хууль зүйн туслалцааны төв болон Монголын Өмгөөлөгчдийн холбооны хамтран баталсан 2024 оны А/3, А/15 дугаар журмаар зохицуулж байна. Өмгөөллийн тухай хуульд заасан нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэх зохицуулалт, Хууль зүйн туслалцааны тухай хуульд заасан үнэ төлбөргүй үзүүлэх хууль зүйн туслалцаанд хувийн өмгөөлөгч оролцуулах зохицуулалтыг уялдуулан практикт тогтсон зарим харилцааг хуульд тусгах замаар өөрчлөн боловсрууллаа.

Энэ нь төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн хүнд үзүүлэх хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулж Монгол Улсын үндсэн хуульд заасан иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахад чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

## **3.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенцийн хэрэгжилттэй холбогдуулан Хүчээр алга болгох асуудал хариуцсан хорооноос Монгол Улсаас

хүргүүлсэн тайланг хэлэлцэж 2021 онд өгсөн зөвлөмжид дараах зөвлөмжийг өгсөн байдаг.

-“Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан Хүчээр алга болгох гэмт хэрэг нь Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенцид заасан тодорхойлолт (“Хүчээр алга болгох” гэдэг нь алга болсон аливаа хүний эрх чөлөөг хассан явдлыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан буюу түүний хувь заяаны талаарх мэдээлэл, эсхүл оршин суугаа газрыг нуусны улмаас тухайн хүнийг хуулийн хамгаалалт эдэлж чадахгүй байдалд хүргэхүйцээр төрийн төлөөлөгчид буюу төрөөс эрх олгогдсон, дэмжлэг буюу зөвшөөрөл авсан этгээдүүд, эсхүл бүлэг этгээдийн тухайн хүнийг баривчлах, саатуулах, хулгайлах, эсхүл бусад хэлбэрээр эрх чөлөөг нь хасахыг хэлнэ”)-оос агуулгын хувьд ихээхэн зөрүүтэй байгааг анхаарч тодорхойлолтыг конвенцид бүрэн нийцүүлэх;

-Эрүүгийн хуульд уг гэмт хэргийн субъект (хүчээр алга болгох үйлдлийг гүйцэтгэсэн, тушаасан, турхирсан буюу өдөөсөн, сэдсэн, оролцсон буюу хамтарч гүйцэтгэсэн, уг үйлдлийг хянаж байсан, эсхүл доод албан тушаалтны үйлдлийг мэдсэн ч зохих арга хэмжээ аваагүй удирдах албан тушаалтан) болон хүндрүүлэх нөхцөлийг дутуу тодорхойлсон байгааг анхаарч конвенцод бүрэн нийцүүлэх; хүчээр алга болгох гэмт хэргийг конвенцийн 5 дугаар зүйлд нийцүүлэн Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт тооцохыг хоёрдмол утгагүйгээр хүлээн зөвшөөрөх;”

Түүнчлэн, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн хэрэгжилттэй холбогдуулан НҮБ-ийн Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсын тайланд өгсөн зөвлөмжид “Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тодорхойлолтыг конвенцийн 1 дүгээр зүйлд заасан “аливаа байдлаар алагчилж, эсхүл айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх зорилгоор эрүүдэн шүүх, мөн гуравдагч этгээдэд хамааралтай байх гэсэнтэй бүрэн нийцүүлэн тодорхойлох” гэж тус тус зөвлөсөн.

Иймд Эрүүгийн хуулийн зарим зохицуулалтыг олон улсын хүний эрхийн гэрээ конвенцод нийцүүлэх шаардлагаар тухайлбал, Эрүүгийн хуулийн эрүүдэн шүүх гэмт хэргийн шинжийг олон улсын конвенцид нийцүүлэн өргөжүүлж, хүчээр алга болгох гэмт хэрэг, хууль бусаар хорих гэмт хэргийн шинжээс ялгаатай байдлыг тодотгон хууль бусаар хорих гэмт хэрэг гэж өөрчлөн тусгаж, харин хүчээр алга болгох гэмт хэргийг Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг гэсэн бүлэгт шилжүүлэн тусгалаа.

#### **4.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төсөл**

Монгол Улсын Их Хурлаас 2017 баталсан Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 17 бүлэг, 255 зүйл, 1058 хэсэг, 908 заалттай бөгөөд тус хуулийн тусгай ангид нийт 2300 орчим үйлдлийг зөрчилд тооцож, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах зохицуулалттай байна. Тус хуулийн төсөлд хүний эрх, эрх чөлөөг хангах дэвшилтэт зохицуулалтыг бий болгох, зүй ёсны хэрэгцээ шаардлагыг харгалзах, хүний эрх эрх чөлөөнд зөвхөн хуулиар хязгаарлалт тогтоох олон улсын хүний эрхийн гэрээ конвенц, Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалыг баримтлан дараах өөрчлөлтийг тусган боловсрууллаа.

Түүнчлэн, НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан ажлын хэсгийн 2022 онд Монгол Улсад хийсэн айлчлалын дүгнэлтдээ 2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж байгаа үйл ажиллагаанд санаа

зовниж байгаа болон хүний эрх чөлөөг хасах нь хамгийн эцсийн шатанд авах арга хэмжээ байх ёстой гэдгийг сануулсан байдаг. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлд заасны дагуу хүний эрх чөлөөг хангах үүднээс баривчлах шийтгэл оногдуулж буй үйлдлүүдийн цар хүрээг Засгийн газар дахин нэг нягталж үзэх нь зүйтэй талаар зөвлөснийг мөн харгалзан үзлээ.

Ерөнхий ангийн хувьд:

Зөрчлийн тухай хуулийн 3.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт шүүх баривчлах шийтгэлийг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд оногдуулах ба жирэмсэн эмэгтэй, арван дөрөв хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эх, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүнд оногдуулахгүй байхаар заасан.

Хуулийн төсөлд тусгасанаар дээр дурдсан хүнээс гадна 0-3 насны хүүхэдтэй эх, хүнд өвчтэй хүнийг асран хамгаалж байгаа хүнийг нэмж тусган, арван дөрөв хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эх гэснийг арван зургаа хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх гэж өөрчлөн тусгалаа. Түүнчлэн хүндэтгэн үзэх бусад шалтгаантай хүн гэж мөн нэмж, энэхүү байдлыг шүүхээс тогтоох байдлаар шийдвэрлэхээр тусгасан болно.

Ийнхүү баривчлах шийтгэлийг оногдуулахгүй байх этгээдийн хүрээ хязгаарыг иргэдийн зүй ёсны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн харьцангуй өргөжүүлэн тусгалаа.

Тусгай ангийн хувьд:

“Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2022”-т тусгаснаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчсөн зөрчил 10095 бүртгэгдсэн нь 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд прокурорын байгууллагад бүртгэгдсэн зөрчлийн дундаж үзүүлэлтэй харьцуулахад 2022 онд нийт зөрчилд эзлэх хувь өссөн үзүүлэлттэй байна. Ийнхүү 2022 онд бүртгэгдсэн 10095 зөрчилд нийт 395 хүнийг 8195 баривчилсан байна. Өөрөөр хэлбэл тус зөрчлийн 80 хувьд нь баривчлах шийтгэл оногдуулсан байна.

Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, бусадтай харилцахыг хязгаарласан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан үйлдлүүдэд баривчлах шийтгэл оногдуулах зохицуулалт үйлчилж байна. Гэтэл хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд тус гэр бүлийн хүчирхийллийн зөрчил нийт бүртгэгдсэн зөрчлийн эхний 5 зөрчилд байнга бүртгэгдэж ирсэн бөгөөд ийнхүү гэр бүлийн хувьд нэгийг баривчлах шийтгэл оногдуулж ирсэн нь энэ төрлийн шийтгэл оновчтой, үр дүнтэй биш гэдэг нь нотлогдож байна.

Харин гэр бүлийн зөрчлийг анх удаа үйлдэж байгаа, эсхүл гэр бүлийн маргаанаас үүдэн гарсан зөрчилд юуны түрүүнд баривчлах шийтгэл оногдуулахгүйгээр уян хатан зохицуулалтыг бий болгох, албан сургалтад хамруулах, нөлөөллийн арга хэмжээ авах, ажил хөдөлмөр эрхлэх боломж олгох нь үр дүнтэй байж болох тул харин гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон буюу биед нь халдсан үйлдэлд баривчлах шийтгэл оногдуулахаар өөрчлөн тусгалаа. Энэ талаар эрх бүхий байгууллагын судалгаа, дүгнэлт, гэр бүлийн

асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал ирүүлснийг үндэслэсэн болно.

Мөн гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюулын үед эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, тэдгээрийн дэглэм зөрчсөн, эсхүл саад учруулсан зөрчил оногдуулах баривчлах шийтгэлийг хасаж боловсруулав.

Түүнчлэн, Улсын Их Хурлаас 2021 онд Хөдөлмөрийн тухай хууль, Гадаадаас ажиллах хүч авах, ажиллах хүч гадаадад гаргах тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийг баталсан боловч тус хуультай холбогдуулан зөрчилд тооцох үйлдэл, түүнд оногдуулах шийтгэлийг Зөрчлийн тухай хуульд шинэчлэн тусгаж батлаагүй байна. Иймд Хөдөлмөрийн тухай хууль зөрчих, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль зөрчих гэсэн зүйлүүдийг өөрчлөн найруулсан болно.

### **5.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Монгол Улсын Их Хурлаас Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталж, 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байна.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2019 оны “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 07 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төрийн үйл ажиллагаан дахь цахим шилжилтийг дэмжих, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг цахим хэлбэрээр явуулж болох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Зөрчлийн бүртгэл, хяналтын нэгдсэн систем”-ийн үйл ажиллагааны эрх зүйн орчинг бий болгохоор тусгалаа.

2022 онд “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийн туршилтын ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлүүлж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс албан ёсоор ашиглалтад оруулж, хэрэглээнд нэвтрүүлэх талаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэл гарч хэрэгжиж эхлээд байна.

Үүнтэй холбогдуулан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны шуурхай байдлыг хангах, цахимын багц хуулийг хэрэгжилтийг дэмжих хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болон шүүх, прокурор, эрх бүхий албан тушаалтнуудад бий болдог хүндрэл, чирэгдлийг багасгах, цахим үйл ажиллагааг нэвтрүүлэх, цахим хэлбэрээр зөрчлийн хэргийг бүртгэх, дугаар олгох, шалгах, хянан шийдвэрлэх талаар зохицуулалт тусгалаа. Энэ нь тухайн зөрчлийг орон зайнаас үл хамааран, шуурхай, зөрчил шалгах бүхий л зардлыг хэмнэсэн, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хууль хэрэгжих нөхцөл боломжийг бүрдүүлсэн.

Түүнчлэн, шийтгэл оногдуулсан шийдвэр, шийтгэлээс чөлөөлөх шийдвэрийн хуудсыг цахим хэлбэрээр хүргүүлж, оногдуулж байх зэрэг хууль зүйн үндэслэлүүд, хуулийг хэрэглэдэг болон хэрэгжүүлж ажилладаг эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн санал, практик шаардлагын дагуу зарим төрлийн хэргийн харьяалалд бий болсон алдааг засахаар боловсрууллаа.

### **6.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Монгол Улсын Их Хурлаас Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль баталсантай холбогдуулан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталж, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэл хэвээр үйлчлэхээр заасан.

2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд Цагдаагийн байгууллагын алба хаагчийн бэлэн бус хэлбэрээр оногдуулсан 354,099 зөрчлийн торгох шийтгэлийн биелэлт хариуцах үүрэг бүхий эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанаас хамаарч өнөөдрийг хүртэл биелэгдээгүй байна.

Биелэлт хангагдаагүй шийдвэрийн 2445 нь 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Зөрчлийн тухай хуулиар зөрчилд тооцохгүй болсон /Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэгт заасан/, 449 шийдвэр шийтгэл, албадлагын арга хэмжээг хөнгөрүүлсэн /Жолоочийн даатгалын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх хэсэгт заасан/ зөрчил байна. Мөн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 46 зүйл, заалтаар хүн, хуулийн этгээдийн зөрчилд оногдуулсан 291,911 шийдвэрийн 75,764 буюу 26.0 хувьд оногдуулах шийтгэлийг Зөрчлийн тухай хуулиар 2.000-190.000 төгрөгөөр хөнгөрүүлж, эрх зүйн байдлыг дээрдүүлсэн байна.

2021 оны “Өршөөл үзүүлэх тухай” хуульд 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө 2002 оны Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөсөн атал уг цаг хугацаанд зөрчил үйлдэж шийтгэл оногдуулсан хүн, хуулийн этгээдийг хамааруулаагүй нь Монгол улсын үндсэн хуулиар хамгаалагдсан “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэх эрх ашиг зөрчигдсөн гэж үзэхээр байна.

Иймд Зөрчлийн тухай хуулиар зөрчилд тооцохгүй болсон, оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээг хөнгөрүүлсэн, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдал нь дээрдсэн хуулийг буцаан хэрэглэх, зохицуулалтын хүрээнд хуулийн хийдэл, зөрчлийг арилгаж, хүний эрхийг сэргээх зорилгоор Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

## **7.Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 18 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн нь улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.” гэж заасан.

1994 онд баталсан Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх буюу хилийн хоригтой холбоотой асуудлыг хүчин төгөлдөр үйлчилж байгаа тус хуульд үндэслэл, хугацааг тусгасан боловч хилийн хоригийн талаарх мэдээллийг бүрдүүлэхэд эрх бүхий байгууллагуудын олон тусдаа шийдвэрээр

баталсан журмууд хэрэгждэг, нэгдсэн бүртгэл байхгүй тул уг үйл ажиллагааг боловсронгуй болгох, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, харилцан мэдээлэл солилцох зохицуулалтыг бий болгох шаардлага байсаар байна.

Иймээс хуульд тусгасан Монгол Улсын иргэний Монгол Улсын хилээр гарах эрхийг түдгэлдүүлэх үндэслэлийг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөн найрууллаа. Ингэхдээ хуурамч, бусдын паспорт, баримт бичиг ашигласан, эсхүл 2 буюу түүнээс дээш удаа өөрийн буруугаас гадаад паспортаа гэмтээсэн, хаяж үрэгдүүлсэн этгээдийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр 2 жил хүртэл хугацаагаар Монгол Улсын хилээр гарахыг түдгэлзүүлэх зохицуулалт үйлчилж ирснийг хасахаар боловсрууллаа. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх үндэслэл байгаа эсэхэд нийслэлд улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутагт цагдаагийн байгууллага хяналт тавих зохицуулалт мөн шаардлагагүй гэж үзсэн болно.

“Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн мэдээллийн нэгдсэн сан”-д Шүүх, Цагдаа, Тагнуул, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын харьяа Интерполын Үндэсний төв товчоо зэрэг байгууллагаас 2014 оноос хойш Монгол Улсын болон гадаадын иргэн (харьяалалгүй хүн) 675 иргэнийг улсын хилээр нэвтэрсэн тохиолдолд мэдэгдэх тайлбартайгаар “хоригтой иргэн” цэсэд бүртгэн, холбогдох байгууллагуудад мэдээ мэдээлэл солилцон ажиллаж байна.

Хил хамгаалах байгууллага нь Монгол Улсын хилийн тухай хуулийн 17.6-д “Улсын хил хамгаалах байгууллага нь зорчигчийн улсын хил нэвтрэх эрхийн баримт бичигт тэмдэглэл хийж, улсын хил нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэлийг хөтөлж, нэгдсэн сан байгуулна”, 17.7-д “Эрх бүхий байгууллагаас зорчигчийг улсын хилээр үл нэвтрүүлэх, саатуулах талаар улсын хил хамгаалах байгууллагад зохих журмын дагуу мэдэгдсэн тохиолдолд түүнийг улсын хилээр нэвтрүүлэхгүй”, 17.8-д “Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн мэдээллийн нэгдсэн санг ашиглах, мэдээлэл харилцан солилцох журмыг улсын хил хамгаалалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасныг хэрэгжүүлэн “Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн мэдээллийн нэгдсэн сан”-г шинэчлэх ажлын хүрээнд “Гэрэгэ” ХХК-тай хамтран системийн хөгжүүлэлтийг хийж байна. Дээрх байгууллагуудаас ирүүлсэн улсын хилээр нэвтэрснийг мэдэгдэх иргэний мэдээллийг системд “Мэдэгдэх иргэдийн” сан үүсгэн, бүртгэхээр хөгжүүлэлтийг хийж байна.

Ийнхүү Монгол Улсын иргэнийг Монгол Улсын хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх журмыг боловсронгуй болгох, хилийн хориг тавих эрх бүхий байгууллагуудын уялдаа холбоог хангах, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар баталсан “Хүүхдийг улсын хилээр нэвтрүүлэх журам”-аар зохицуулж байгаа харилцааг хуулийн төсөлд тусгах, ингэхдээ Улсын Их Хурлаас 2024 онд баталсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн тусгалаа.

## **8.Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Харилцаа холбооны тухай хуульд заасны дагуу өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэн харилцаа холбооны зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр



гаргах чиг үүрэгтэй Харилцаа холбооны зохицуулах хороо нь дарга болон 6 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Зохицуулах хорооны дарга, гишүүд нь Харилцаа холбооны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 268 дугаар тогтоолоор баталсан дүрэмд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Харилцаа холбооны зохицуулах хороо хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ улс төрөөс хараат, хамааралтай байх нь хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлах буюу мэдээллийн агуулгад хяналт тогтоох боломжтой тул хорооны дарга, гишүүдийг томилж байгаа одоогийн тогтолцоог өөрчлөх шаардлагатай талаар хэд хэдэн судалгаанд онцолжээ. Тухайлбал, АНУ-ын төрийн департаментын Монгол Улсын 2019 оны хүний эрхийн тайланд “Харилцаа холбооны зохицуулах хороо нь дижитал болон телевиз радиогийн нэвтрүүлгийн агуулгад ерөнхий нөхцөлөөр хориг хязгаарлалт тогтоох эрх хэмжээтэйг онцлоод уг хорооны гишүүдийг олон нийтийн оролцоог хангаагүйгээр томилж байгаа, мөн хорооны гишүүд улс төрд танил талтай хүмүүст давуу тал олгож байгааг шүүмжилжээ.”<sup>1</sup>

Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүдийн хараат бус байдлыг хангах, иргэний нийгмийн болон мэргэжлийн байгууллагын бодит оролцоог хангах, тэдгээрийг нээлттэй сонгон шалгаруулалтаар томилох зохицуулалтыг бий болгох зохицуулалтыг тусгалаа.

## **9.Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь хэсэгт “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.” гэж заасан.

2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан, 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаар хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг албаны нууцад хамааруулж тогтоохгүй байхаар заасан.

Монгол Улсад нийт 39 төрийн байгууллагын төрийн нууцад хамаарах мэдээлэл 572, албаны нууцад хамаарах мэдээлэл 1043 байна.<sup>2</sup>

Гэвч төрийн байгууллага, албан тушаалтнууд хуульд ил тод, нээлттэй байхаар заагаагүй бөгөөд нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг “албаны нууц”-д хамааруулан тогтоох боломжтой байгаа албаны нууцын талаарх эрх зүйн зохицуулалт буюу Төрийн болон албаны нууцын тухай хууль дахь зохицуулалт нь иргэний Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон мэдээлэл авах эрхийг хөндөхөд хүрч байна гэсэн шүүмж гарсаар байна.

---

<sup>1</sup> Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл. О.Мөнхсайхан, Р.Очирбал. Хүний эрх-Дэвшилтэт бодлогын хүрээлэн 2021 он. 109 дүгээр хуудас.

<sup>2</sup> Тагнуулын ерөнхий газраас ХЗДХЯ-д албан бичгээр ирүүлсэн тоон мэдээлэл 2022 он

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд заасан, иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хуульд ил тод, нээлттэй байхаар заагаагүй бөгөөд нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг албаны нууцад хамааруулахгүй байх, үүний тулд албаны нууцад хамааруулах мэдээллийн шалгуур үзүүлэлтийг тусгалаа.

#### **10.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх бүхий хуульчдад /шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, бусад хуульч/ олон улсын гэрээ конвенцын ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, уг асуудлыг хуульчийн үргэлжилсэн сургалтын хөтөлбөрт тусгах хөшүүрэг бий болгохоор хуулийн 55 дугаар зүйл буюу хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах гэсэн хэсэгт хуульчийн үргэлжилсэн сургалтын агуулга нь Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, шинээр батлагдсан хууль тогтоомжийг таниулах, хуульчийн мэргэжлийн ур чадвар, мэдлэг, ёс зүйг нэмэгдүүлэх, хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх дадал төлөвшүүлэхэд чиглэгдэх агуулга бүхий зохицуулалт нэмэхээр боловсрууллаа.

#### **11.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл**

Монгол Улс 1961 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагад элсэн орсноос хойш Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний гүшүүн байгууллагуудаас батлан гаргасан хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой 70 гаруй гэрээнд нэгдэн ороод байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассемблейн тогтоолоор батлагдсан Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактаар хүний хувийн халдашгүй байдлын эрхийг баталгаажуулсан байдаг бөгөөд энэхүү эрхийн хүрээнд хүний орон байр, өмч нь халдашгүй байхаар хамгаалагдсан.

Хөгжлийн томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх явцад иргэний өмчид халдах, албадан нүүлгэх үйл ажиллагаа явагддаг бөгөөд энэхүү ажиллагаанд хүний хувийн халдашгүй байдал буюу хүний өмч халдашгүй байх, орон байр халдашгүй байх эрх хөндөгддөг.

Иймд хөгжлийн төлөө төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхдээ үүсч болох эрсдэл, хохирлыг бууруулах үүднээс хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн байх болон тухайлан хүний эрхийн судалгаа хийх агуулгыг тусгалаа.

Түүнчлэн, Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хүрээнд “Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний II хөтөлбөр”, “Эрх зүйн шинэтгэлийн II хөтөлбөр”-ийг батлуулж, хэрэгжүүлэхээр заасан. Мөн Монгол Улсын Их Хурлын “Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2023 оны 114 дүгээр тогтоолоор “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр-2”-ыг батлан, хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан байдаг.

Иймд дээрх хөтөлбөрийг батлах эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх, хөгжлийн зорилтот хөтөлбөр буюу дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болгон хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхээр тус хуульд нэмэлт оруулахаар тусгалаа.

---o0o---